



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
СОЁЛ УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 04 сарын 29 одор

Дугаар 1/15

Сайншанд сум


Төрийн албан хаагчийн сургалтын  
болон ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг  
хангах хөтөлбөрийг батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь заалт, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.6 дахь згэлт, 67.5 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Соёлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.9 дэх заалт, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6 дахь заалт, Хөдөлмөрийн дотоод журмын 2 дугаар зүйлийн 2.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн  
**ТУШААХ** нь:

- 1.“Соёл, урлагийн газрын албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг хавсралтаар баталсугай.
2. Уг хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон зардлыг тухайн жилийн төсөвт тусгаж зориулалтын дагуу зарцуулахыг нягтлан бодогч /Б.Батзангиа/-д үүрэг болгосугай.
- 3.Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тайлagnаж ажиллахыг Захиргаа, удирдлагын жолтэст даалгасугай.



44201000032



Соёл, урлагийн газрын 12-ны 4 дугаар  
сарын 29-ны өдрийн 11/5 дугаар тушаалын  
хавсралт

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН АЛБАН  
ХААГЧДЫН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН  
БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨР**

Нэг. Хөтөлбөрийн үндэслэл, шаардлага

**1.1 Хөтөлбөр боловсруулах үндэслэл**

Монгол Улсын Үндсэн хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь заалт, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Соёлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.9 дэх заалт, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6 дахь заалтууд нь энэхүү хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх нь эрх зүйн үндэс болно.

**Өнөөгийн байдал:**

Соёл урлагийн газар нь МУЗГ-ын 2021 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 168 дугаар тогтоол, Соёлын сайдын 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн A/04 дугаар тушаал, Аймгийн засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн A/655 дугаар захирамжийн дагуу 11 орон тоотойгоор, үүнээс удирдах ажилтан-3, гүйцэтгэх ажилтан 8 орон тоотойгоор батлагдсан ба одоогоор 8 орон тоонд, удирдах ажилтан 2, гүйцэтгэх ажилтан 6 ажиллуулж байгууллагын цалингийн сангаас цалинжуулсан байна.

Байгууллагын албан хаагчдын 25 хувь нь эрэгтэй, 75 хувь нь эмэгтэй албан хаагч байгаа ба насны хувьд 25 хүртэлх насын-2, 25-34 насын-1, 35-44 насын-4, 45-55 насын-1 албан хаагч ажиллаж байна.

**1.2 Хөтөлбөр боловсруулах шаардлага**

Төрийн шатны бүх байгууллагын үр нөлөө, үр ашигтай үйл ажиллагаа явуулах гол нөөц нь мэдлэг чадвар бөгөөд гадаад, дотоод орчны байнгын өөрчлөлт нь төрийн албан хаагчдаас цаг үргэлж мэдлэг, чадвараа дээшлүүлж байх хэрэгцээг бий болгож байна.

Төрийн албаны өөрчлөлт, шинэчлэлийг даган төрийн захиргааны байгууллага нь мэдлэг чадвартай албан хаагчдын хүчээр төрийн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх, иргэдэд ойр, сэтгэлгээний болон үр чадварын хувьд өөрчлөгдөн шинэчлэгдэх, шинийг эрэлхийлэгч, олон талт, өргөн цар хүрээтэй мэдлэг чадвар бүхий хүний нөөцтэй байх, хүний нөөцөө тасралтгүй хөгжүүлж байх шаардлагатай байна.

**1.3 Энэхүү хөтөлбөрт Дорноговь аймгийн Соёл, урлагийн газрын нийт ажилтан, албан хаагчид хамрагдана.**

## **Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт**

2.1 Зорилго: Төрийн албан хаагчдын хууль тогтоомжоор олгогдсон эрхийг эдлүүлэхээс гадна ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, эрүүл мэндийг хамгаалах, мэргэшүүлж сургах, гэр бүлийг дэмжих зэрэг асуудлыг шийдвэрлэн хэрэгжүүлж албан хаагчдын үр бүтээлтэй, баталгаатай, тогтвортой суурьшилтай ажиллах, албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлнэ

### **2.2 Хөтөлбөрийн зорилт**

2.2.1 Албан хаагчдад цалин хөлс, нөхөн төлбөр, тусlamж, тэтгэмж олгох, шагнаж урамшуулах

2.2.2 Албан хаагчдын ажиллах нөхцөл, баталгааг хангах, мэдлэг чадварыг дээшлүүлэх

2.2.3 Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх

2.2.4 Албан хаагчдын мэргэшлийн ур чадварыг үе шаттайгаар дээшлүүлэх замаар мэдлэг чадвартай төрийн захиргааны албан хаагчидтай болсон байх

## **Гурав. Хөтөлбөрийн хамрах хүрээ, зарчим**

### **3.1 Хөтөлбөрийн хамрах хүрээ**

Дорноговь аймгийн Соёл, урлагийн газрын албан хаагчид хамрагдана.

### **3.2 Хөтөлбөрийн зарчим**

-нээлттэй, ил тод байх

-хууль дээдлэх

-мэргэшсэн тогтвортой байх

-хариуцлага хүлээдэг байх

-чанар хүртээмжтэй байх

## **Дөрөв. Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа, удирдлага зохион байгуулалт**

4.1 Хөтөлбөр нь цаг хугацааны хувьд дунд хугацааны буюу 2022-2025 онд хэрэгжих хөтөлбөр байна.

4.2 Энэхүү хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж дагаж мөрднө.

4.3 Хөтөлбөрийн хэрэгжилтийг салбарын хэмжээнд уялдуулан зохицуулах, хяналт тавих, жил бүрийн хэрэгжилтийг хангаж тайлгахаа үүргийг Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга хариуцна.

## **Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл**

5.1. Албан хаагчдад цалин хөлс, нөхөн төлбөр, тусlamж, тэтгэмж олгох, шагнаж урамшуулах ажлын хүрээнд:

5.1.1. Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоолоор баталсан цалингийн сүлжээг баримтлан Төрийн албан хаагчийн албан тушаалын цалин, нэмэгдлийг ажилласан жил, мэргэжлийн ур чадвар, туршлага, ажлын үр дүнг харгалзан нэмэгдүүлж тухай бүр шинэчлэн тогтоож олгоно.

5.1.2. Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт болон ажлын үр дүнг харгалзан ажилтнуудад улирал болон хагас, бүтэн жилийн үр дүнгийн урамшуулалт олгоно.

5.1.3. Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт болон ажлын үр дүнг харгалзан зэрэг дэв нэмэгдүүлэх саналыг холбогдох журмын дагуу уламжилна.

5.1.4. Албан хаагчдад сар бүр хоол унааны мөнгийг 4000 төгрөгөөр тооцож олгоно.

5.1.5. Төрийн дээд одон медаль болон салбарын шагналын болзол хангасан албан хаагчдыг шагналд тодорхойлохыг хамт олны саналыг үндэслэн холбогдох байгууллагад уламжилна.

5.1.6. Ажилтан үндсэн ажлынхаа зэрэгцээ ажил, албан тушаал хавсрان ажиллах, эзгүй байгаа ажилтны үүргийг орлон гүйцэтгэх, албан тушаалын тодорхойлолтод заагаагүй ажил, үүргийг гүйцэтгэх тохиолдолд ажилтны саналыг харгалзан байгууллагын захиргаа шийдвэр гаргах бөгөөд цалин хөлсийг нэмэгдүүлж олгоно.

5.1.7. Амралт, баяр ёслол, онцгой байдлын үед илүү цагаар ажилласан албан хаагчдад илүү цагийн хөлсийг удирдлагын шийдвэрээр олгоно.

5.1.8. Ээлжийн амралтаараа өөрийн болон эхнэр, нөхрийн төрсөн нутагт амарсан ажилтнуудад унааны зардлыг нийтийн тээврийн тарифаар 2 жилд нэг удаа (ТАТХ-ийн 59.1.6 дахь заалт) олгоно.

5.1.9. Гэр болон галлагаатай байшинд амьдардаг албан хаагчдад түлээ, нүүрс худалдан авах, өрх толгойлсон эмэгтэйд гэр бүлд дэмжлэг болгож байгууллагаас жилд нэг удаа 200.000 (хоёр зуун мянган) төгрөгийн дэмжлэг үзүүлнэ.

4.4 Соёл, урлагийн үйл ажиллагааны онцлог болон эзэмшсэн мэргэжлээс хамаарч гадаад дотоодын сургалтад хамрагдсан мэдлэг чадвар бүхий сургагч багшийг сонгож авна.

## 5.2. Албан хаагчдын ажиллах нөхцөл, баталгааг хангах, мэдлэг чадварыг дээшлүүлэх ажлын хүрээнд:

5.2.1. Албан тушаалын тодорхойлолтыг нарийвчлан боловсруулж, албан хаагчдын ажлын ачааллыг жигдруулж ажил үүргийн хуваарийг батлан мөрдүүлнэ.

5.2.2. Албан хаагчдын ажил үүргээ гүйцэтгэхдээ шаардлагатай техник хэрэгслээр хангах, ээлж дараалалтай шинэчлэх, бичиг хэргийн хэрэгслээр тогтмол хангана.

5.2.3. Байгууллагын ажилтнуудыг дүрэмт хувцсаар жигдруулнэ.

5.2.4. Албан хаагчдыг ажлаас нь хөндийрүүлэхгүйгээр бодлогын баримт бичиг боловсруулах, төрийн захиргааны онолын болон албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр ажлын байран дээрх сургалтыг зохион байгуулна.

## 5.3. Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх ажлын хүрээнд:

5.3.1. Албан хаагчдыг нарийн мэргэжлийн эмч нарын урьдчилан сэргийлэх үзлэгт жилд нэг удаа хамруулах, биеийн дархлааг сайжруулах зорилгоор улирал бүр витаминжуулах, гарах зардлыг байгууллага хариуцна.

5.3.2. Албан хаагчдыг рашаан сувилалд сувилуулах, гадаадад эмчлүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлэх, магадлан итгэмжлэл бүхий сувилалд амрах тохиолдолд ирэх, буцах унааны зардлыг нийтийн тээврийн тарифаар тооцож (ТАТХ-ийн 59.1.6 дахь заалт) олгоно.

5.3.3. Ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор спортын уралдаан, тэмцээн, цасны баяр, аялал зохион байгуулахад 2 тал хамтран зохион байгуулж, санхүүжилтийг зөвшилцэн шийдвэрлэнэ.

**5.4 Албан хаагчдын мэргэшлийн ур чадварыг үе шаттайгаар дээшлүүлэх замаар мэдлэг чадвартай төрийн захиргааны албан хаагчидтай болсон байх ажлын хүрээнд:**

5.4.1 Ажилтнуудын өөрөө өөрийгөө удирдан хөгжүүлэх чадварыг нэмэгдүүлэн ажлын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлж, хариуцлагын тогтолцоог нэмэгдүүлэх

5.4.2 Төрийн албан хаагчийн мэдээллийн шинэ технологийн хэрэглээ, хангамжийг нэмэгдүүлэх

5.4.3 Сургалтын төрөлжсөн байгууллага болон гадаад орнуудын оюуны хөрөнгө оруулалтыг татах орчин нөхцлийг бүрдүүлэх

5.4.4 Дээд шатны байгууллагын албан хаагчдыг дагалдан ажиллах, бусад аймаг сум байгууллагаас туршлага судлах, ажлын харилцаа тогтоох

5.4.5 Сургалтын үр дүнг үнэлж дүгнэн үр дүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулж хэвших

5.4.6 Албан хаагчдыг мэргэжил, гадаад хэлний чиглэлээр мэргэшүүлэх, чадваржуулах, гадаад дотоодод сургах хэрэгцээг судалж жил бүр төлөвлөгөөтэйгээр сургах, мэргэшүүлэх ажлыг тогтмол үр дүнтэй зохион байгуулна.

5.4.7 Албан хаагчдыг гадаадын өндөр хөгжилтэй орнуудад ажлын туршлага судлах, сургалтад хамрагдах санал санаачилгыг дэмжих, богино хугацааны зорилtot сургалтад албан томилолт олгон тухай бүр хамруулна.

### **Зургаа. Хөтөлбөрийн санхүүжилт**

Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

6.1 Улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө

6.2 Гадаад, дотоод улс болон олон улсын байгууллагаас хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөр

6.3 Бусад эх үүсвэр

## **Долоо. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хүрэх үр дүн**

- 7.1 Мэргэшсэн өндөр мэдлэг, чадвартай төрийн албан хаагчдыг бэлтгэснээр байгууллагын чиг үүргийн хүрээнд шуурхай чанартай үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.
- 7.2 Мэргэшсэн төрийн албан хаагчид тогтвортой суурьшилтай ажиллах боломж нэмэгдэнэ.
- 7.3 Газрын хэмжээнд төрийн албан хаагчдыг бэлтгэх, давтан сургах тогтолцоо бүрдэж, төрийн албан хаагчдын байнга суралцсан хөгжих боломж нөхцөл хангагдана.

## **Найм. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт**

- 8.1 Хөтөлбөрийн хэрэгжилтийг жил бүрийн 1 дүгээр сард багтаан танилцуулна
- 8.2 Хөтөлбөрийн үйл ажиллагааг үнэлж дүгнэсний үндсэн дээр дараагийн ажлыг нарийвчлан тодорхойлно.
- 8.3 Хэрэгжилтийн талаар байгууллагын удирдлага, ажилтан тодорхой санал гаргаж хөтөлбөрт тодотгол хийн нэмэлт өөрчлөлт оруулж болно

---оо---